

“ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ” ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Үйлдвэрлэл технологийн парк ОНӨААТҮГ -ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2022/09/НА-СА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn Дархан-Уул аймаг 2022 он	Тэргүүлэх аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч: Ш.Мөнхбаяр Утас: 7037-3089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 7037-3089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: “Дундманхайдай аудит” ХХК Захирал : Ж.Бямбажав Цахим хаяг: dum_audit@yahoo.com Утас: 11-325262 Утас: 91991462
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн Ерөнхий ба удирдлагын зардлын гүйцэтгэл.....	9
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Дотоод хяналт.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Материаллаг байдал	10
4. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
4.1 Байгууллагын үйл ажиллагаа	11
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	11
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого.....	12
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	13
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
8. Аудитын илрүүлэлт.....	14

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.Аудитын санал дүгнэлт



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР


45059 Дархан-Уул аймаг,
Дархан сум, 14-р баг
Утас: 7037-3089, Факс: (975) 7037-3089
E-mail: darkhanuul@audit.gov.mn

2022.03.15 № 238

танай -ны № -т

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН "ҮЙЛДВЭРЛЭЛ
ТЕХНОЛОГИЙН ПАРК" ОНӨААТҮГ-ЫН
ДАРГА Д.БАТБАЯР ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



Зөрчилгүй санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Үйлдвэрлэл технологийн парк ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Үйлдвэрлэл технологийн парк ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

Тайлант онд хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 1 хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт 99.6 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 51.2 хувийн биелэлттэй байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Бусад асуудал

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага нь үйл ажиллагааг зогсоох юмуу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа бэлтгэхдээ тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

009020313

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.МӨНХБАЯР

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ
ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨААТҮГ-ЫН
ДАРГА Д.БАТБАЯР ТАНАА

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Зөрчилгүй санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Үйлдвэрлэл технологийн парк ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Үйлдвэрлэл технологийн парк ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч байгууллагаас хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

Тайлант онд хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 1 хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт 99.6 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 51.2 хувийн биелэлттэй байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Бусад асуудал

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага нь үйл ажиллагааг зогсоох юмуу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа бэлтгэхдээ тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ҮҮРГИЙГ

ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.МӨНХБАЯР

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	150,564.33	32,910.90
1.1.2	Дансны авлага	0.00	93,020.00
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	137,964.57	137,964.57
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	288,528.90	263,895.47
1.2.1	Үндсэн хөрөнгө	4,166,163.88	4,166,163.88
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4,166,163.88	4,166,163.88
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	4,454,692.78	4,430,059.35
2.1.1.1	Дансны өглөг	0.00	300,000.00
2.1.1.2	Цалингийн өглөг	0.00	1,181,024.76
2.1.1.3	Татварын өр	1,000.47	376,974.95
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,000.47	1,857,999.71
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,000.47	1,857,999.71
2.3	Өмч	10,528,740.00	10,528,740.00
2.3.1	төрийн	10,528,740.00	10,528,740.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	2,785,092.06	2,785,092.06
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-8,860,139.75	-10,741,772.42
2.3.11	Эздийн өмчийн дүн	4,453,692.31	2,572,059.64
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	4,454,692.78	4,430,059.35

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	47,636,500.00	23,331,800.00
3	Нийт ашиг (алдагдал)	47,636,500.00	23,331,800.00
8	Бусад орлого	0.00	333,300.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	49,339,490.69	25,546,732.67
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-1,702,990.69	-1,881,632.67
20	Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-1,702,990.69	-1,881,632.67
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-1,702,990.69	-1,881,632.67
24	Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	-1,702,990.69	-1,881,632.67

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-8,860,139.75	-8,860,139.75
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.	0.
3	Залруулсан үлдэгдэл	-8,860,139.75	-8,860,139.75
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.	0.
5	Бусад дэлгэрэнгүй орлого	0.	0.
6	Өмчид гарсан өөрчлөлт	0.	0.
7	Зарласан ногдол ашиг	0.	0.
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.	0.
9	2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-8,860,139.75	-8,860,139.75
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.	0.
11	Залруулсан үлдэгдэл	-8,860,139.75	-8,860,139.75
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-1,881,632.67	-1,881,632.67
13	Бусад дэлгэрэнгүй орлого	0.	0.
14	Өмчид гарсан өөрчлөлт	0.	0.
15	Зарласан ногдол ашиг	0.	0.
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.	0.
17	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-10,741,772.42	-10,741,772.42

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1.1	Мөнгөн орлогын дүн	47,636,500.00	23,665,100.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	47,636,500.00	23,331,800.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	0.00	333,300.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	47,631,651.67	23,782,753.43
1.2.1	Ажиллагчдад төлсөн	29,740,878.27	13,772,362.17
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	3,951,760.43	4,789,916.53
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	0.00	358,400.00
1.2.4	Ашиглалтын зардал төлсөн	5,045,000.00	3,780,890.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	400,000.00	0.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	1,704,983.97	923,290.73
1.2.9	Бусад мөнгөн зарлага	6,789,029.00	157,894.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	4,848.33	-117,653.43
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	4,848.33	-117,653.43
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	150,564.33
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	150,564.33	32,910.90

2.5 Аудит хийсэн Ерөнхий ба удирдлагын зардлын гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт	Хувь
1	Ажиллагчдын цалингийн зардал	31,654.8	18,514.1	(13,140.7)	58.5
2	Аж ахуйн нэгжээс төлсөн НДШ-ийн зардал	3,951.8	2,528.5	(1,423.3)	64.0
3	Албан татвар, төлбөр, хураамжийн зардал	31.1	32.2	1.1	103.5
4	Томилолтын зардал	154.0		(154.0)	-
5	Бичиг хэргийн зардал	1,762.6	369.2	(1,393.4)	20.9
6	Шуудан холбооны зардал	331.0	20.8	(310.2)	6.3
7	Мэргэжлийн үйлчилгээний зардал	4,120.0		(4,120.0)	-
8	Элэгдэл, хорогдлын зардал	757.7		(757.7)	-
9	Түрээсийн зардал	5,045.0	3,760.0	(1,285.0)	74.5
10	Харуул хамгааллын зардал	300.0		(300.0)	-
11	Шатахууны зардал	400.0		(400.0)	-
12	Программын эрхийн зардал	352.0		(352.0)	-
13	Зар сурталчилгааны зардал	479.5		(479.5)	-
14	Банкны шимтгэлийн зардал		21.9	21.9	-
15	Нийт дүн	49,339.5	25,246.7	(24,092.8)	51.2
16	Санхүүжилт	49,339.5	23,331.8	(26,007.7)	47.2

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн Үйлдвэрлэл технологийн парк ОНӨААТҮГ -ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд тус газрын дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2022 оны 01 дүгээр сарын 10-наас 2022 оны 03 дугаар сарын 15-ны хооронд Дундманхайдай Аудит ХХК-ийн захирал Ж.Бямбажав хянан удирдаж, чанарын хяналтын менежер Б.Цэвэлмаа, аудитор С.Батжаргал, аудиторов туслах С.Ариунтунгалаг нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан-Уул аймгийн Үйлдвэрлэл технологийн парк ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланг “Дундманхайдай аудит” ХХК-д 2022 оны 01 дугаар сарын 24- ний өдрийн 04 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Дархан-Уул аймгийн Үйлдвэрлэл технологийн парк ОНӨААТҮГ-ын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус газар нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулаагүй байна.

Тайланд хугацаанд тус газарт хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Дархан-Уул аймгийн Үйлдвэрлэл технологийн парк ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны дэлгэрэнгүй орлогын тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны дэлгэрэнгүй орлогын тайлангийн нийт зардлын 25.3 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 0.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Үйлдвэрлэл технологийн парк ОНӨААТҮГ-ын зорилго нь “Хүний эрүүл мэнд, байгаль орчинд халгүй, дэвшилтэт техник технологи нэвтрүүлэх импортыг орлох, экспортын баримжаатай үйлдвэрлэлийг хөгжүүлэх” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилт нь оршино.

Дархан-Уул аймгийн Үйлдвэрлэл технологийн парк ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны чиглэлийг бизнес эрхлэгч байгууллагын үйл ажиллагааг дэмжих гэж тодорхойлжээ.

Тус байгууллага нь “ОНӨААТҮГ” гэсэн статустай бөгөөд 100 хувь орон нутгийн өмчид харьяалагдаж байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Үйлдвэрлэл технологийн парк ОНӨААТҮГ нь Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2011 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 74 тогтоолыг үндэслэн 2011оны 11 дүгээр сарын 02 –ний өдрийн 01 дугаар тогтоолоор улсын бүртгэлд бүртгүүлэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Дархан-Уул аймгийн Үйлдвэрлэл технологийн парк ОНӨААТҮГ-ын удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүн нь өөрийгөө санхүүжүүлэх эх үүсвэргүй, байгууллагын үйл ажиллагаа нь зогссоноос шалтгаалан ажиллаагүй байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;”-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцийг 2021оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс өөрчилж, чиг үүргийн давхардлыг арилгаж орон тоог 1 хүнээр бууруулсан, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан хавсран гүйцэтгэгчээр 5 сар ажил үүргийг гүйцэтгүүлсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна.

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Дархан-Уул аймгийн Үйлдвэрлэл технологийн парк ОНӨААТҮГ -ын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31	Өөрчлөлт
Мөнгөн хөрөнгө	150.5	32.9	(117.7)
Дансны авлага	0.0	93.0	93.0
Татвар, НДШ – ийн авлага	137.9	137.9	-
Үндсэн хөрөнгө	4,166.1	3,832.8	(333.3)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	4,454.6	4,096.7	(357.9)
Цалингийн өглөг	0.0	1,181.0	1,181.0
Татварын өр	1.0	376.9	376.0
Төрийн өмч	10,528.7	10,528.7	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	2,785.0	2,785.0	-
Хуримтлагдсан ашиг	(8,860.1)	(10,775.0)	(1,914.9)
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	4,454.6	4,096.7	(357.9)

Банк дахь мөнгөний үлдэгдэл 32.9 мянган төгрөг болж, харилцах дансаар 27,231.8 мянган санхүүжилт авч, цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, түрээсийн болон бичиг хэрэг, шуудан холбооны зардалд 27,349.4 мянган төгрөг зарцуулсан байна.

Авлагын үлдэгдэлд ААНОАТ-ын авлага 137.9 мянган төгрөг, хувь хүнээс авах авлага 93.0 мянган төгрөг байна.

Богино хугацаат өр төлбөр 1,557.9 мянган төгрөгийн өр төлбөр байна. Энэ нь цалингийн өглөгт 1,181.0 мянган төгрөг, 4-р улирлын ХХОАТ 376.9 мянган төгрөг байна.

Зардал өмнөх онтой харьцуулахад үйл ажиллагааны зардал 23.8 төгрөгөөр хасагдсан нь үйл ажиллагаа түр зогссоноос шалтгаалжээ.

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Үйлдвэрлэл технологийн парк ОНӨААТҮГ -ын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Тайлант жил 2020 оны Аймгийн ИТХ-ын №2/02 тоот тогтоолоор Дархан-Уул аймгийн Үйлдвэрлэл технологийн парк ОНӨААТҮГ -ын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 47,006.9 мянган төгрөгөөр, нийт зардлыг 47,006.9 төгрөгөөр байхаар тогтоосон байна.

Гүйцэтгэлээр 23,331.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 25,246.7 мянган төгрөгийн зардал гарган, (1,914.9) төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл төлөвлөснөөс 23,401.8 төгрөг буюу 47.7% хувиар тасарсан нь 2021 оны 04-р сараас байгууллагын удирдлага чөлөөлөгдөж, 4 дүгээр сараас 12 сар хүртэл санхүүжилт орлогын эх үүсвэргүйгээс нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл төлөвлөснөөс 25,546.7 сая төгрөг буюу 45.7% хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь байгууллагын үндсэн ажилчдыг чөлөөлж дарга болон нягтлан бодогчийн хавсран гүйцэтгүүлэн үйл ажиллагааг түр зогсоосон нь гол нөлөө үзүүлсэн байна.

Тайлант онд 1,914.9 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Тайлант онд 47,066.9 мянган төгрөгийн үйл ажиллагааны зардал төсөвлөснөөс, цалингийн зардалд 18,814.1 мянган төгрөг, аж ахуйн нэгжээс төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 2,528.5 мянган төгрөг, бичиг хэрэг, шуудан холбооны зардалд 390.1 мянган төгрөг, түрээсийн зардалд 3,760.0 мянган төгрөг, бусад зардалд 54.1 мянган төгрөгийн зардал гарсан байна.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Тайлант онд нийт 25,546.7 мянган төгрөгийн 127 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг ил тод байршуулсан байна.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудит удирдлага, нягтлан бодогч томилогдоогүй үйл ажиллагаа зогссоноос шалтгаалан хийгээгүй болно.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 692.1 мянган төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгснөөс зөвлөмж 100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	4	692.1	4	692.1			
Нийт дүн	4	692.1	4	692.1			

/мянган төгрөг/

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх асуудал байхгүй болно.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 30.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэнд төлбөрийн акт тогтоолоо.

8.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай залруулгыг хийгээгүй болно.

8.2 Төлбөрийн акт

Аудитаар 30.7 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоов. Үүнд:

Тайлант хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийг 30,700.74 төгрөгийг илүү шилжүүлсэн байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д "Ажил олгогч болон энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагч нь шимтгэл төлөх талаар дор дурдсан үүрэг хүлээнэ: 3/нийгмийн даатгалын холбогдолтой анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журмын дагуу хөтөлж, тайлан тэнцэл гаргах" гэсэнтэй тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох хууль, эрхзүйн актыг мөрдөх, төлбөрийн акт тогтоов.

8.3 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал гараагүй болно.

8.4 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөх асуудал гараагүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Дархан-Уул аймгийн “Үйлдвэрлэл технологийн парк” ОНӨААТҮГ	1	30.7	-	-	1	30.7	-	-	-	-
	Дүн	1	30.7	-	-	1	30.7	-	-	-	-

“Дундманхайдай аудит” ХХК

Огноо: 2022.03.15

